

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын эрүүл мэндийн төвийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын хураангуй тайлан**

Аудитын код: ХӨА-2026/083/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг: [ariuntuyab@audit.gov.mn](mailto:ariuntuyab@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: [Munkhtuya2220@gmail.com](mailto:Munkhtuya2220@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/НТ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БААТАР ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төв нь 2025 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 162,572.0 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 44,326.9 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс, 35,927.0 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 8,399.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага хүргүүлсэн.

#### Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 88.4 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>381,170,923.93</b>	<b>375,982,739.37</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	21,833,234.77	29,199,887.85
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	21,833,234.77	29,199,887.85
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	21,833,234.77	29,199,887.85
31211	Төрийн сангийн харилцах	21,833,234.77	29,199,887.85
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	183,194,152.62	162,572,052.93
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	183,194,152.62	162,572,052.93
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	176,143,536.54	184,210,798.59
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	43,834,480.15	47,545,519.10
35130	Эм боох материал	43,834,480.15	47,545,519.10
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	132,309,056.39	136,665,279.49
35410	Бичиг хэргийн материал	4,591,544.00	4,184,270.00
35420	Аж ахуйн материал	26,878,746.31	28,109,531.91
35450	Барилгын засварын материал	245,000.00	00.00
35460	Хүнсний материал	5,637,074.00	5,173,785.50
35470	Бусад хангамжийн материал	94,956,692.08	99,197,692.08
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>560,573,990.20</b>	<b>744,633,378.75</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	560,573,990.20	744,633,378.75
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	541,421,240.17	720,471,628.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	352,104,900.90	342,731,247.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-98,685,677.84	-109,464,522.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	94,750,999.94	213,868,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-46,917,527.50	-74,621,289.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	298,581,169.79	431,925,454.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-105,111,268.71	-146,200,303.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,871,582.76	94,485,041.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,172,939.17	-32,251,999.24
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	19,152,750.03	24,161,750.03
39301	Програм хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-602,249.97	-833,249.97
39303	Бусад биет бус хөрөнгө	18,600,000.00	23,840,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>941,744,914.13</b>	<b>1,120,616,118.12</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	22,111,662.45	5,519,679.43
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	5,519,679.43
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	22,111,662.45	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	22,111,662.45	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>919,633,251.68</b>	<b>1,115,096,438.69</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	919,633,251.68	1,115,096,438.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	889,082,412.08	889,082,412.08
51101	Өмч: - төрийн	889,082,412.08	889,082,412.08
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-24,653,945.79	171,112,823.98
51210	Өмнөх үеийн үр дүн	-24,653,945.79	-24,350,363.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	195,463,187.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	55,204,785.39	54,901,202.63
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>941,744,914.13</b>	<b>1,120,616,118.12</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,590,841,990.51</b>	<b>1,835,505,584.90</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>222,858,089.90</b>	<b>403,939,462.30</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	222,858,089.90	403,939,462.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	222,858,089.90	403,939,462.30
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,788,176.00	58,727,161.60
120017	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-үндсэн хөрөнгө	125,151,225.34	320,129,666.00
120018	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	49,918,688.56	25,082,634.70
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,367,983,900.61</b>	<b>1,431,566,122.60</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	89,385,100.00	90,322,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,385,100.00	90,322,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,278,598,800.61	1,341,243,622.60
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,278,598,800.61	1,341,243,622.60
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,435,036,662.27</b>	<b>1,640,028,197.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,435,036,662.27</b>	<b>1,640,028,197.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,379,589,509.49	1,571,344,630.70
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	924,244,558.64	1,051,786,363.80
210101	Үндсэн цалин	510,525,898.91	542,250,452.00
210102	Нэмэгдэл	300,933,320.85	373,399,259.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,941,000.00	34,960,000.00
210104	Урамшуулал	91,844,338.88	101,176,652.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	107,751,882.00	123,956,355.99
210201	Тэтгэврийн даатгал	73,256,340.00	85,600,303.05
210202	Тэтгэмжийн даатгал	8,617,881.00	9,613,905.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,350,209.00	5,097,200.54
210204	Ажилгүйдлийн даатгал	4,304,190.00	4,638,830.12
210205	Эрүүл мэндийн даатгал	17,223,262.00	19,006,116.84
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	63,715,823.22	67,528,210.81
210301	Гэрэл, цахилгаан	4,881,478.22	7,026,780.81
210302	Түлш, халаалт	50,385,145.00	52,082,230.00
210303	Цэвэр, бохир ус	8,449,200.00	8,419,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	50,218,503.39	50,260,217.32
210401	Бичиг хэрэг	3,891,984.00	5,075,084.00
210402	Тээвэр, шатахуун	30,246,800.00	29,237,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,040,000.00	2,995,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	435,290.00	296,999.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,019,320.00	7,340,915.40
210408	Бараа материал акталсны зардал	9,585,109.39	5,314,968.92
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	116,438,584.83	100,262,443.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	108,587,845.83	88,316,464.83
210502	Хоол, хүнс	7,850,739.00	11,945,978.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,907,000.00	23,724,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	181,500.00	00.00
210604	Урсгал засвар	14,725,500.00	23,724,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,110,000.00	2,621,000.00
210702	Дотоод албан томилолт	1,110,000.00	2,621,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,894,550.00	6,355,762.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	2,216,300.00	4,574,000.00

	үйлчилгээний төлбөр хураамж		
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	254,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,338.00	101,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	36,000.00
210807	Газрын төлбөр	96,312.00	96,312.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	916,600.00	1,294,050.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>97,308,607.41</b>	<b>144,850,277.45</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,854,214.00	3,730,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,454,393.41	141,120,277.45
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,447,152.78</b>	<b>68,683,567.19</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>41,753,176.00</b>	<b>58,214,778.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	20,575,954.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	41,753,176.00	37,638,824.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>13,693,976.78</b>	<b>10,468,789.19</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,693,976.78	10,468,789.19
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>155,805,328.24</u></b>	<b><u>195,477,387.01</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>155,805,328.24</u></b>	<b><u>195,477,387.01</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,250,833,615.99</u></b>	<b><u>1,510,915,383.89</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>47,788,176.00</b>	<b>58,727,161.60</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	47,788,176.00	58,727,161.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,788,176.00	58,727,161.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,788,176.00	58,727,161.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,203,045,439.99</b>	<b>1,452,188,222.29</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	89,385,100.00	90,322,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,385,100.00	90,322,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,113,660,339.99</b>	<b>1,361,865,722.29</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,113,660,339.99	1,361,865,722.29
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,267,354,988.99</u></b>	<b><u>1,498,498,730.81</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,267,354,988.99</b>	<b>1,498,498,730.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,211,907,836.21</b>	<b>1,429,815,163.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	924,244,558.64	1,046,266,684.37
210101	Үндсэн цалин	510,525,898.91	536,730,772.57
210102	Нэмэгдэл	300,933,320.85	373,399,259.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,941,000.00	34,960,000.00
210104	Урамшуулал	91,844,338.88	101,176,652.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>107,751,882.00</b>	<b>123,956,355.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	73,256,340.00	85,600,303.05
210202	Тэтгэмжийн даатгал	8,617,881.00	9,613,905.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,350,209.00	5,097,200.54
210204	Ажилгүйдлийн даатгал	4,304,190.00	4,638,830.12
210205	Эрүүл мэндийн даатгал	17,223,262.00	19,006,116.84
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>63,715,823.22</b>	<b>67,528,210.81</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,881,478.22	7,026,780.81
210302	Түлш, халаалт	50,385,145.00	52,082,230.00
210303	Цэвэр, бохир ус	8,449,200.00	8,419,200.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	37,618,550.00	39,752,130.00
210401	Бичиг хэрэг	2,881,500.00	2,883,000.00
210402	Тээвэр, шатахуун	29,390,200.00	30,721,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,040,000.00	2,995,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	656,400.00	637,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,650,450.00	2,515,080.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	47,925,909.35	102,938,700.45
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,520,309.35	92,558,200.45
210502	Хоол, хүнс	6,205,600.00	9,420,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,200,000.00	960,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	17,600,000.00	27,431,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	350,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	3,302,000.00
210604	Урсгал засвар	17,600,000.00	23,779,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,110,000.00	2,621,000.00
210702	Дотоод албан томилолт	1,110,000.00	2,621,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,092,250.00	7,011,272.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,216,300.00	4,665,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	254,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,338.00	101,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	36,000.00
210807	Газрын төлбөр	96,312.00	96,312.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,114,300.00	1,857,960.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,848,863.00	12,309,810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,848,863.00	12,309,810.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,447,152.78</b>	<b>68,683,567.19</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	41,753,176.00	58,214,778.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	20,575,954.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	41,753,176.00	37,638,824.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	13,693,976.78	10,468,789.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,693,976.78	10,468,789.19
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-16,521,373.00</b>	<b>12,416,653.08</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>5,050,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>5,050,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	5,050,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	5,050,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-5,050,000.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-16,521,373.00	7,366,653.08
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	38,354,607.77	21,833,234.77
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	21,833,234.77	29,199,887.85

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	889,082,412.08	55,204,785.39	-180,459,274.03	763,827,923.44
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	155,805,328.24	155,805,328.24
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>889,082,412.08</b>	<b>55,204,785.39</b>	<b>-24,653,945.79</b>	919,633,251.68
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	303,582.76	303,582.76
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>889,082,412.08</b>	<b>55,204,785.39</b>	<b>-24,350,363.03</b>	919,936,834.44
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-303,582.76	00.00	-303,582.76
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	195,427,237.01	195,427,237.01
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>889,082,412.08</b>	<b>54,901,202.63</b>	<b>171,076,873.98</b>	1,115,060,488.69

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**  
Улсын төсвийн гүйцэтгэл:

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/Төгрөгөөр/
					Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,729,227,700.00</b>	<b>1,420,592,883.89</b>	<b>308,634,816.11</b>	<b>82.15</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>1,729,227,700.00</b>	<b>1,420,592,883.89</b>	<b>308,634,816.11</b>	<b>82.15</b>
120	Нийтлэг татварын бус орлого	133,066,100.00	58,727,161.60	74,338,938.40	44.13
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	133,066,100.00	58,727,161.60	74,338,938.40	44.13
122	Тусламжийн орлого	1,596,161,600.00	1,361,865,722.29	234,295,877.71	85.32
122001	Хандив тусламж /дотоод/	1,596,161,600.00	1,361,865,722.29	234,295,877.71	85.32
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,751,061,000.00</b>	<b>1,413,226,230.81</b>	<b>337,834,769.19</b>	<b>80.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,751,061,000.00</b>	<b>1,413,226,230.81</b>	<b>337,834,769.19</b>	<b>80.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,618,472,200.00</b>	<b>1,355,011,452.81</b>	<b>263,460,747.19</b>	<b>83.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хэлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,125,162,900.00</b>	<b>1,046,266,684.37</b>	<b>78,896,215.63</b>	<b>92.99</b>
210101	Үндсэн цалин	518,383,200.00	536,730,772.57	(18,347,572.57)	103.54
210102	Нэмэгдэл	437,872,300.00	373,399,259.40	64,473,040.60	85.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,880,000.00	34,960,000.00	9,920,000.00	77.90
210104	Урамшуулал	124,027,400.00	101,176,652.40	22,850,747.60	81.58
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>152,867,800.00</b>	<b>123,956,355.99</b>	<b>28,911,444.01</b>	<b>81.09</b>
210201	Тэтгэврийн даатгал	105,523,000.00	85,600,303.05	19,922,696.95	81.12
210202	Тэтгэмжийн даатгал	11,836,400.00	9,613,905.44	2,222,494.56	81.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,918,200.00	5,097,200.54	820,999.46	86.13
210204	Ажилгүйдлийн даатгал	5,918,200.00	4,638,830.12	1,279,369.88	78.38
210205	Эрүүл мэндийн даатгал	23,672,000.00	19,006,116.84	4,665,883.16	80.29
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>84,087,200.00</b>	<b>39,752,130.00</b>	<b>44,335,070.00</b>	<b>47.27</b>
210401	Бичиг хэрэг	6,257,200.00	2,883,000.00	3,374,200.00	46.07
210402	Тээвэр, шатахуун	61,132,200.00	30,721,450.00	30,410,750.00	50.25
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,869,500.00	2,995,000.00	2,874,500.00	51.03
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	6,163,300.00	637,600.00	5,525,700.00	10.35

	ариутгал				
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,665,000.00	2,515,080.00	2,149,920.00	53.91
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	128,261,900.00	102,938,700.45	25,323,199.55	80.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	106,470,000.00	92,558,200.45	<b>13,911,799.55</b>	<b>86.93</b>
210502	Хоол, хүнс	17,591,900.00	9,420,500.00	8,171,400.00	53.55
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,200,000.00	960,000.00	3,240,000.00	22.86
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	88,924,700.00	16,505,500.00	72,419,200.00	18.56
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,500,000.00	1,750,000.00	<b>29,750,000.00</b>	<b>5.56</b>
210602	Тавилга	26,300,000.00	00.00	26,300,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,000,000.00	3,302,000.00	6,698,000.00	33.02
210604	Урсгал засвар	21,124,700.00	11,453,500.00	9,671,200.00	54.22
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,500,000.00	2,621,000.00	2,879,000.00	47.65
210702	Дотоод албан томилолт	5,500,000.00	2,621,000.00	<b>2,879,000.00</b>	<b>47.65</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,633,600.00	7,011,272.00	6,622,328.00	51.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,261,300.00	4,665,600.00	<b>4,595,700.00</b>	<b>50.38</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	00.00	1,152,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	254,400.00	95,600.00	72.69
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,000.00	101,000.00	124,000.00	44.89
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	36,000.00	63,000.00	36.36
210807	Газрын төлбөр	380,000.00	96,312.00	283,688.00	25.35
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,166,300.00	1,857,960.00	308,340.00	85.77
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20034100.00	15959810.00	4,074,290.00	79.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,034,100.00	15,959,810.00	<b>4,074,290.00</b>	<b>79.66</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	132,588,800.00	58,214,778.00	74,374,022.00	43.91
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	132,588,800.00	58,214,778.00	<b>74,374,022.00</b>	<b>43.91</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	61,074,000.00	20,575,954.00	<b>40,498,046.00</b>	<b>33.69</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	71,514,800.00	37,638,824.00	33,875,976.00	52.63
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИИТ ТЭНЦЭЛ</b>	<b>(21,833,300.00)</b>	<b>7,366,653.08</b>		
<b>9</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>21,833,300.00</b>	<b>(7,366,653.08)</b>		
<b>7</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>21,833,300.00</b>	<b>(7,366,653.08)</b>		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	21,833,234.77		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	29,199,887.85		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	90,322,500.00	79,853,710.81	10,468,789.19	88.41
12	Татварын бус орлого	90,322,500.00	79,853,710.81	10,468,789.19	88.41
122	Тусламжийн орлого	90,322,500.00	79,853,710.81	10,468,789.19	88.41
122005	Төсвөөс санхүүжих	90,322,500.00	79,853,710.81	10,468,789.19	88.41
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,322,500.00	79,853,710.81	10,468,789.19	88.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	90,322,500.00	79,853,710.81	10,468,789.19	88.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,322,500.00	79,853,710.81	10,468,789.19	88.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,997,000.00	67,528,210.81	10,468,789.19	86.58
210301	Гэрэл, цахилгаан	8,089,700.00	7,026,780.81	1,062,919.19	86.86
210302	Түлш, халаалт	59,458,100.00	52,082,230.00	7,375,870.00	87.59
210303	Цэвэр, бохир ус	10,449,200.00	8,419,200.00	2,030,000.00	80.57
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,325,500.00	12,325,500.00	-	100.0
210604	Урсгал засвар	12,325,500.00	12,325,500.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 44,326.9 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс, 35,927.0 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 8,399.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага хүргүүлсэн.

#### 3.1 Залруулсан алдаа

- Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлэхдээ тайлант оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй, Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтын дагуу тайланг бэлтгэж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад нөхөж гаргасан.
- Нийгмийн эрүүл мэндийн зардалд зарцуулсан 8,574.0 мянган төгрөгийн бичиг хэрэг, эм, хүнсний материалыг үр дүнгийн тайланд холбогдох зардалд тусгаагүй бусад зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байсныг аудитын явцад залруулсан.
- Татвар, НДШ-ийн өглөг 5,519.7 мянган төгрөгийг бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байсныг аудитын явцад илрүүлэн бүртгэлд тусгасан.
- Тайлант жилд шинээр орлогод авсан 16,140.0 мянган төгрөгийн 9 үндсэн хөрөнгийг орлогод авахдаа ашиглалтын хугацааг оруулж өгөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг 21,833.3 мянган төгрөгөөр зөрүүтэй бэлтгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитаар залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 8,399.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 22,960.6 мянган төгрөгөөс 14,560.7 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### **3.2. Албан шаардлага**

Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 36, зарлагын 16 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэж заасан заалттай нийцэхгүй байна. Иймд зөрчил таслан зогсоох тухай албан шаардлагыг хүргүүлсэн.

### **3.3. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Төлбөртэй үйлчилгээний орлоготой холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчид үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, жагсаалтыг гаргаж батлаагүй, шүдний эмчилгээний төлбөрийн орлогыг төвлөрүүлээгүй байгаа нь Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, Засгийн газрын тусгай сан болон аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээ, бусад үйл ажиллагааны орлого, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.” Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Жагсаалт, журам батлах тухай” А/216 дугаар тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/А/118 тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”-тай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Хууль журамд нийцүүлэн төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээг баталж мөрдөх

#### **2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн бүлэг хооронд 8,399.9 мянган төгрөгийн гүйлгээг эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 заалтад заасан “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд худалдан авах ажиллагааны тайланг хавсаргаагүй.	1	-	1	-			1	-		
Татвар, НДШ-ийн шимтгэлийн өглөгийг тайланд тусгаагүй	1	5,519.7	1	5,519.7			1	5,519.7		
Нийгмийн эрүүл мэндийн зардлаас бэлтгэсэн бичиг хэрэг, эм, хүнсний материалыг үр дүнгийн тайланд холбогдох зардалд нь бүртгээгүй, бусад зардлаар бүртгэсэн.	1	8,574.0			1	8,574.0	1	8,574.0		
Үндсэн хөрөнгийг орлогод авахдаа ашиглалтын хугацааг оруулаагүй	1	-	1	-			1	-		
Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй бэлтгэсэн.	1	21,833.3			1	21,833.3	1	21,833.3		
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>35,927.0</b>	<b>3</b>	<b>5,519.7</b>	<b>2</b>	<b>30,407.3</b>	<b>5</b>	<b>35,927.0</b>		

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээг баталж мөрдөөгүй, шүдний орлого төвлөрүүлээгүй.	1	-					1	-
Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн.	1	8,399.9					1	8,399.9
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>8,399.9</b>					<b>2</b>	<b>8,399.9</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй .	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>		

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			